



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2025/005/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.25 № 1607
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь аудитын дүгнэлт өгөх үндэслэл болно.

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн нийт 377,868.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 4, 5, 6, 14, 15, 16, 22, 69 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4, 13, 14, 18, 19, 20 дугаар зүйл, Газрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, ангилал, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 377,868.8 сая төгрөгийн алдаа, зөрчил нь өмнөх оноос 11.4 дахин өссөн;
- Зарим харьяа байгууллагуудын газрыг санхүүгийн тайланд бүртгээгүй, газар эзэмших эрхийн гэрчилгээгүй, газрын зориулалтыг үйл ажиллагааны бус зорилгоор өөрчилсөн, хувь хүнд ашиглуулсан зэрэг зөрчлүүд байна. Үүнд:
 - Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт орших 7469 м.кв нөөц удирдлагын төв бүхий газарт хувь хүнтэй аман тохиролцоо хийж, газрын хойд хэсэгт хашаа бариулж ашиглуулсан;

- Иргэний нисэхийн ерөнхий газар нийт 225,972 м.кв талбай бүхий 5 газрыг бүртгээгүй, 3 газар эзэмших эрхийн гэрчилгээгүй;
- Иргэний нисэхийн үндэсний төв шатахуун түгээх станцын 59648 м.кв газрыг МИАТ ТӨХК-аас балансаас баланст шилжүүлэн авч газрын зориулалтыг үйлчилгээтэй орон сууц болгон өөрчилсөн, хөдөө орон нутагт байрлах 5 газар эзэмших эрхийн гэрчилгээгүй;
- МИАТ ТӨХК нь өөрийн газар эзэмших эрхийн зориулалтыг үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн өөрчлүүлээгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх нийт 737,123.5 сая төгрөгийн 126 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Үүнээс авто замын төсөлд 86.9 хувь буюу 689,505.3 сая төгрөгийг, гүүр болон гүүрийн байгууламжийн төсөлд 5.0 хувь буюу 39,660.1 сая төгрөгийг, тээврийн төсөлд 1.0 хувь буюу 7,958.1 сая төгрөгийг тус тус баталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Япон Монголын хамтарсан Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт ХХК нь Чингис хаан Олон Улсын нисэх буудлын менежментийг хариуцан ажилладаг. Тус компанийн 49.0 хувийг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК, 51.0 хувийг Япон улсыг төлөөлж, Жапан эйрпорт менежмент ХХК эзэмшиж байна. Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК нь 100.0 хувь төрийн өмчит хуулийн этгээд бөгөөд нийт хувьцааны эрхийн 66.0 хувийг Зам, тээврийн яам, 34.0 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн тайланд Олон улсын шинэ нисэх онгоцны буудлын хөрөнгө бүртгэлтэй бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт жилд 8,500.0 сая төгрөгийг төлж, 64,621.3 сая төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулж, зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал боомтын хил холболтын төмөр замын төслүүдийг тэргүүлэх 14 мега төслийн нэг болгон зарласан байна.

“Шивээхүрэн-Сэхээ” боомтын хил дамнасан төмөр замын Монголын нутаг дэвсгэр дээрх хэсгийг ашиглалтад хүлээн авсан бөгөөд хил холболтын төмөр замын төслүүд хэрэгжиж, боомтын хөгжлийг цогцоор нь дэвшилтэт технологитой уялдуулан хөгжүүлснээр экспортын хэмжээг нэмэгдүүлж, ашигт малтмалын ордуудын үнэлэмжийг өсгөж, эдийн засгийн эргэлтэд оруулах шинэ боломжууд бүрдэхээр байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага


Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,565,879,869.5	1,917,749,912.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	197,608,009.7	359,865,085.3
33	АВЛАГА	259,239,119.7	249,544,543.9
34	УРЬДЧИЛГАА	57,556,618.5	71,738,546.3
35	БАРАА МАТЕРИАЛ	89,173,893.1	102,189,602.1
36	НӨӨЦИЙН БАРАА	803.9	0.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	962,301,424.5	1,134,412,135.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,244,045,945.6	7,438,232,935.8
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	742,417,070.7	742,417,070.7
37200	Үнэт цаас	693,765,710.7	693,765,710.7
37300	Урт хугацаат зээл	48,651,360.0	48,651,360.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,501,628,874.9	6,695,815,865.1
39200	Биет хөрөнгө	5,543,596,007.2	5,581,658,579.5
39300	Биет бус хөрөнгө	926,113,945.8	1,080,633,135.3
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	31,918,921.9	33,524,150.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,809,925,815.1	9,355,982,848.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,492,297,570.9	2,843,424,439.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	414,711,025.3	510,081,175.7
41200	Богино хугацаат зээлийн өглөг	38,204,900.0	38,029,988.0
41300	Өглөг	290,286,178.5	275,849,972.0
41400	Урьдчилж орсон орлого	86,219,946.8	196,201,215.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,077,586,545.7	2,333,343,263.5
42100	Урт хугацаат үнэт цаас	1,336,123,253.7	1,475,504,630.9
42200	Урт хугацаат зээл	741,463,292.0	857,838,632.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,317,628,244.1	6,512,558,409.4
51	Засгийн газрын хувь оролцоо	6,317,514,893.5	6,512,445,058.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,288,684,411.2	2,172,015,649.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	93,809,162.1	94,446,382.9
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	490.0	490.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	32,583.8	32,583.8
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	805,231,252.1	945,126,023.4
51200	Хуримтлагдсан үр дүн	867,043,920.2	1,042,633,293.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,262,713,074.1	2,257,974,343.2
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.0	216,293.0
52	Хяналтын бус хувь оролцоо	113,350.6	113,350.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,809,925,815.1	9,355,982,848.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	589,297,219.6	1,562,431,417.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	252,548,841.8	869,022,234.7
120	Нийтлэг татварын бус орлого	252,548,841.8	869,022,234.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	336,748,377.8	693,409,182.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	741,971,353.0	951,054,722.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	741,971,353.0	951,054,722.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	735,954,210.1	857,634,745.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,870,435.9	106,261,097.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,243,144.9	13,488,840.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	566,120.2	4,087,709.6
2104	Хангамж, бараа материалын зардал	705,577.4	8,684,097.3
2105	Нормативт зардал	26,224.4	126,752.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	309,525.5	4,899,624.2
2107	Томилолт, зочны зардал	968,488.8	3,680,328.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	157,356,528.1	175,055,731.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	564,908,164.9	541,350,563.5
212	ТАТААС	0.0	3,284,421.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,017,142.9	90,135,555.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-152,674,133.4	611,376,695.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3,449,057.4	156,144.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,703,622.2	217,466,514.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-174,928,698.2	394,066,324.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,536,309,923.4	2,306,846,398.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	129.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	129.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,192,738,474.3	1,607,788,269.7
120	Нийтлэг татварын бус орлого	1,192,738,474.3	1,607,788,269.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	343,571,449.1	699,057,999.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,165,512,004.4	1,461,890,371.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,165,512,004.4	1,461,890,371.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,128,030,243.3	1,353,736,500.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,104,147.2	240,452,781.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,768,552.7	46,880,606.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,533,272.1	20,179,792.3
2104	Хангамж, бараа материалын зардал	375,354,893.8	469,634,984.6
2105	Нормативт зардал	28,578.3	37,294.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,553,283.9	2,497,426.3
2107	Томилолт, зочны зардал	2,537,386.9	3,661,276.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	494,654,578.1	565,133,601.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,495,550.4	5,258,737.4
211	ХҮҮ	0.0	83,071.7
212	ТАТААС	5,901,923.7	5,777,693.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,579,837.4	102,293,105.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	370,797,918.9	844,956,026.5
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	3,821,723.6	35,874,612.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	372,073,235.4	755,715,084.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	372,073,235.4	755,715,084.5
2200	Дотоод эх үүсвэрээр	372,073,235.4	755,715,084.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-368,251,511.8	-719,840,472.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	37,217,696.9	37,141,521.6
14	Бусад эх үүсвэр	108,646,304.9	85,751,841.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	71,428,608.0	48,610,319.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	39,764,104.0	162,257,075.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	157,843,905.7	197,608,009.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	197,608,009.7	359,865,085.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,525,419,170.8		6,525,419,170.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-37,315,592.0		-37,315,592.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,488,103,578.8		6,488,103,578.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-4,948,038.3		-4,948,038.3
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	909,196.7		909,196.7
7	Өмчид гарсан өөрчлөлт	9,176,317.2		9,176,317.2
8	Зарласан ногдол ашиг	-684,112.0		-684,112.0
9	Тайлант үеийн үр дүн	-174,928,698.2		-174,928,698.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,317,628,244.1		6,317,628,244.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-215,603,168.3		-215,603,168.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,102,049,065.1		6,102,049,065.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	366,122.7		366,122.7
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	193,527.1		193,527.1
17	Өмчид гарсан өөрчлөлт	19,444,762.4		19,444,762.4
18	Зарласан ногдол ашиг	-3,537,403.2		-3,537,403.2
19	Тайлант үеийн үр дүн	394,066,324.6		394,066,324.6
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,512,558,409.4		6,512,558,409.4

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	817,916,943,200.00	710,770,251,496.33	107,146,691,703.67	86.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,320,305,100.00	23,381,866,344.89	938,438,755.11	96.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,624,969,300.00	19,268,600,285.58	356,369,014.42	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,570,306,200.00	9,309,880,540.14	260,425,659.86	97.3
210101	Үндсэн цалин	5,907,027,800.00	5,442,311,313.83	464,716,486.17	92.1
210102	Нэмэгдэл	2,760,956,800.00	2,268,644,214.26	492,312,585.74	82.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	764,879,500.00	1,141,376,127.22	-376,496,627.22	149.2
210104	Урамшуулал	137,442,100.00	457,548,884.83	-320,106,784.83	332.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,196,538,700.00	1,168,084,613.57	28,454,086.43	97.6
210201	Тэтгэврийн даатгал	813,646,100.00	798,824,333.38	14,821,766.62	98.2
210202	Тэтгэмжийн даатгал	95,723,100.00	95,037,022.39	686,077.61	99.3
210203	ҮОМШӨ-ий даатгал	47,861,500.00	46,662,338.84	1,199,161.16	97.5
210204	Ажилгүйдлийн даатгал	47,861,600.00	45,360,668.07	2,500,931.93	94.8
210205	Эрүүл мэндийн даатгал	191,446,400.00	182,200,250.89	9,246,149.11	95.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,273,100.00	158,273,100.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	24,525,000.00	24,525,000.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	46,107,000.00	46,107,000.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	22,563,000.00	22,563,000.00	0.00	100.0
210304	Байрны түрээс	65,078,100.00	65,078,100.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	276,804,500.00	272,399,413.94	4,405,086.06	98.4
210401	Бичиг хэрэг	69,777,700.00	68,476,940.00	1,300,760.00	98.1
210402	Тээвэр, шатахуун	58,617,000.00	58,483,283.00	133,717.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,564,900.00	70,120,932.96	443,967.04	99.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	77,844,900.00	75,318,257.98	2,526,642.02	96.8
2105	Нормативт зардал	37,234,900.00	37,232,900.00	2,000.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	37,234,900.00	37,232,900.00	2,000.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	620,022,400.00	616,387,263.00	3,635,137.00	99.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	211,897,300.00	211,893,100.00	4,200.00	100.0
210602	Тавилга	28,465,000.00	26,866,815.00	1,598,185.00	94.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,595,000.00	7,594,700.00	300.00	100.0
210604	Урсгал засвар	372,065,100.00	370,032,648.00	2,032,452.00	99.5
2107	Томилолт, зочны зардал	728,449,200.00	712,231,783.00	16,217,417.00	97.8
210701	Гадаад албан томилолт	291,690,500.00	287,261,391.00	4,429,109.00	98.5
210702	Дотоод албан томилолт	436,758,700.00	424,970,392.00	11,788,308.00	97.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,748,610,000.00	6,728,438,576.91	20,171,423.09	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,562,343,800.00	6,552,736,269.19	9,607,530.81	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,575,400.00	2,452,500.00	122,900.00	95.2
210803	Даатгалын үйлчилгээ	6,388,300.00	4,790,700.00	1,597,600.00	75.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,227,600.00	2,574,332.00	653,268.00	79.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,027,900.00	836,400.00	191,500.00	81.4

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	136,735,300.00	136,714,595.72	20,704.28	100.0
210807	Газрын төлбөр	8,932,300.00	4,806,900.00	4,125,400.00	53.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	27,379,400.00	23,526,880.00	3,852,520.00	85.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	288,730,300.00	265,672,095.02	23,058,204.98	92.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,137,900.00	56,152,095.02	985,804.98	98.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	231,592,400.00	209,520,000.00	22,072,400.00	90.5
212	ТАТААС	3,836,119,500.00	3,284,421,292.03	551,698,207.97	85.6
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,836,119,500.00	3,284,421,292.03	551,698,207.97	85.6
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,836,119,500.00	3,284,421,292.03	551,698,207.97	85.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	859,216,300.00	828,844,767.28	30,371,532.72	96.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	235,243,700.00	228,939,554.56	6,304,145.44	97.3
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	235,243,700.00	228,939,554.56	6,304,145.44	97.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	623,972,600.00	599,905,212.72	24,067,387.28	96.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	48,333,400.00	45,976,400.00	2,357,000.00	95.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	241,668,000.00	240,550,000.00	1,118,000.00	99.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	316,903,300.00	296,310,912.72	20,592,387.28	93.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,067,900.00	17,067,900.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	793,596,638,100.00	687,388,385,151.44	106,208,252,948.56	86.6
220001	Барилга байгууламж	735,784,554,300.00	635,254,582,162.88	100,529,972,137.12	86.3
221001	Их засвар	1,338,908,900.00	218,376,393.56	1,120,532,506.44	16.3
223001	Бусад хөрөнгө	56,473,174,900.00	51,915,426,595.00	4,557,748,305.00	91.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	817,916,943,200.00	714,063,981,890.51	103,852,961,309.49	87.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	792,560,943,200.00	685,415,173,399.14	107,145,769,800.86	86.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	792,560,943,200.00	685,415,173,399.14	107,145,769,800.86	86.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,356,000,000.00	28,648,808,491.37	-3,292,808,491.37	113.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,356,000,000.00	28,648,808,491.37	-3,292,808,491.37	113.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	75,148,782.18	-75,148,782.18	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	59,655,777.51	-59,655,777.51	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	-	100.0
610001	Төсвийн байгууллага	4	4	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	567	501	66	88.4
620001	Удирдах ажилтан	23	22	1	95.7
620002	Гүйцэтгэх ажилтан	266	255	11	95.9
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0
620004	Гэрээт ажилтан	275	221	54	80.4

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		8,947,544,631.09
УРСГАЛ ЗАРДАЛ		8,947,544,631.09
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,588,189,473.09
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		440,345,350.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		440,345,350.00
Бараа үйлчилгээний бусад зардал		3,147,844,123.09
Бараа үйлчилгээний бусад зардал		3,147,844,123.09
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,359,355,158.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		5,359,355,158.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		149,546,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		5,209,809,158.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		8,720,885,629.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		8,720,885,629.00
ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,070,731,121.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,650,154,508.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		226,659,002.09

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар залруулагдаагүй нийт 407,795.6 сая төгрөгийн 271 зөрчил илэрснээс 133.2 сая төгрөгийн зөрчилд 35 төлбөрийн акт тогтоож, 313,132.5 сая төгрөгийн зөрчилд 101 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 94,529.9 сая төгрөгийн 134 зөвлөмж, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага өгсөн.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 416,064.4 сая төгрөгийн 41 алдаа илэрснээс 416,019.5 сая төгрөгийн 40 алдааг аудитын явцад залруулж, 44.9 сая төгрөгийн залруулаагүй 1 алдаанд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Зам, тээврийн яам	1	179,169.3			1	179,169.3	1	179,169.3				
2	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	1	894.4	1	894.4			1	894.4	-	-	-	-
3	ЗТЯ-ны хөрөнгө оруулалт, их засвар	1	38,624,739.6			1	38,624,739.6	1	38,624,739.6				
4	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ	5	723,818.4			5	723,818.4	5	723,818.4				
5	Монгол Улсын далайн захиргаа	1	198,701.4			1	198,701.4	1	198,701.4	-	-	-	-
6	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	3	213,742.9	-	-	3	213,742.9	3	213,742.9	-	-	-	-
7	Монголын төмөр зам ТӨХК	4	1,169,653.3	1	171,868.0	3	997,785.3	3	1,124,754.3	1	44,899.0	1	44,899.0
8	МИАТ ТӨХК	3	372,177,310.7	1	368,186,738.9	2	3,990,571.8	3	372,177,310.7	-	-	-	-
9	ИНҮТ	1	3,200.0	1	3,200.0			1	3,200.0	-	-	-	-
10	Архангай АЗЗА ТӨХК	2	207,506.7			2	207,506.7	2	207,506.7	-	-	-	-
11	Багануур АЗЗА ТӨХК	3	967,907.9			3	967,907.9	3	967,907.9	-	-	-	-
12	Баянчандмань АЗЗА ТӨХК	2	207,974.7	1	22.0	1	207,952.7	2	207,974.7	-	-	-	-
13	Булган АЗЗА ТӨХК	1	3,300.0	1	3,300.0			1	3,300.0	-	-	-	-
14	Дархан АЗЗА ТӨХК	1	300.0	1	300.0			1	300.0	-	-	-	-
15	Дорноговь АЗЗА ТӨХК	3	352,000.0			3	352,000.0	3	352,000.0	-	-	-	-
16	Налайх АЗЗА ТӨХК	1	54,700.0			1	54,700.0	1	54,700.0	-	-	-	-
17	Орхон АЗЗА ТӨХК	1	3,000.0			1	3,000.0	1	3,000.0	-	-	-	-
18	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	3	190,908.9			3	190,908.9	3	190,908.9	-	-	-	-
19	Талын зам ТӨХК	2	334,100.0			2	334,100.0	2	334,100.0	-	-	-	-
20	Харгуй ТӨХК	1	2,702.3			1	2,702.3	1	2,702.3	-	-	-	-
21	Хөвсгөл АЗЗА ТӨХК	1	448,747.2			1	448,747.2	1	448,747.2	-	-	-	-
	НИЙТ ДҮН	41	416,064,377.7	7	368,366,323.3	34	47,698,054.4	40	416,019,478.7	1	44,899.0	1	44,899.0

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зам, тээврийн сайд	10	29,926,813.0			1	-	1	-	8	29,926,813.0
2	Зам, тээврийн яам	14	6,248,115.2	1	3,654.1	8	5,857,916.4			5	386,544.7
3	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	5	26,475.7	2	13,875.7	3	12,600.0				
4	Авто замын норм, нормативын сан	3	409,875.0							3	409,875.0
5	ЗТЯ-ны хөрөнгө оруулалт	4	1,082,807.1			2	1,082,807.1			2	-
6	Улсын авто замын сан	7	1,218,271.4	3	14,932.4	3	1,083,892.1			1	119,446.9
7	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ	9	554,916.2	2	8,714.2	3	105,189.1			4	441,012.9
8	Монгол Улсын далайн захиргаа	10	706,972.4	3	49,006.6	4	627,965.8			3	30,000.0
9	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	5	75,935.3	1	3,940.9	3	71,994.4			1	-
10	Монголын төмөр зам ТӨХК	8	1,966,837.6	1	4,024.0	4	1,914,534.1			3	48,279.5
11	МИАТ ТӨХК	8	5,242,334.7			5	5,015,572.8			3	226,761.9
12	Авто импекс ТӨҮГ	15	1,328,202.8	1	1,500.0	3	23,542.7			11	1,303,160.1
13	Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨҮГ	7	255,059.6			1	95,888.6			6	159,171.0
14	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХК	4	89,508.9			3	78,029.9			1	11,479.0
15	Шивээ хүрэн төмөр зам	2	24,196.8			1	9,446.9			1	14,749.9
16	Иргэний нисэхийн үндэсний төв	66	218,260,288.2	7	6,290.4	20	188,064,202.5			39	30,189,795.4
17	ИНЕГ	11	47,133,723.5			9	33,234,924.3			2	13,898,799.2
18	ИНЕГ – түүвэр	7	88,030,610.6			5	72,742,067.4			2	15,288,543.2
19	Архангай АЗЗА ТӨХК	5	760,617.2	1	3,063.6	4	757,553.6				
20	Багануур АЗЗА ТӨХК	4	6,875.0							4	6,875.0
21	Баянчандмань АЗЗА ТӨХК	3	1,007,226.7			1	934,944.9			2	72,281.8
22	Булган АЗЗА ТӨХК	5	171,082.5	3	10,812.5					2	160,270.0
23	Говь-Алтай АЗЗА ТӨХК	8	15,563.9			6	13,148.6			2	2,415.3
24	Дархан АЗЗА ТӨХК	9	94,792.5	2	2,807.0	2	24,233.9			5	67,751.6
25	Дорноговь АЗЗА ТӨХК	1	-							1	-
26	Налайх АЗЗА ТӨХК	9	780,032.8	3	2,837.3	2	578,495.5			4	198,700.0
27	Орхон АЗЗА ТӨХК	10	115,998.9	4	3,011.9	4	112,987.0			2	-
28	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	1	-							1	-
29	Талын зам ТӨХК	8	1,252,583.3			2	319,687.2			6	932,896.1
30	Төв АЗЗА ТӨХК	2	29,870.5	1	4,750.0					1	25,120.5
31	Увс АЗЗА ТӨХК	1	2,100.0			1	2,100.0				
32	Ховд АЗЗА ТӨХК	5	577,095.6							5	577,095.6
33	Хөвсгөл АЗЗА ТӨХК	4	400,820.3			1	368,812.1			3	32,008.2
34	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	1	-							1	-
	НИЙТ ДҮН	271	407,795,603.2	35	133,220.6	101	313,132,536.7	1	-	134	94,529,845.9

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн нэгтгэсэн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар илэрсэн нийт 120,083.6 сая төгрөгийн 84 зөрчил илэрснээс 3.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 68,613.4 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 51,467.2 сая төгрөгийн 61 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зам, тээврийн сайд	2	-			1	-	1	-
2	Зам, тээврийн яам	7	20,793,610.2	1	2,000.0	3	68,564.1	3	20,723,046.1
3	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	4	8,861.7					4	8,861.7
4	Улсын авто замын сан	5	55,695,755.5			2	38,930,170.4	3	16,765,585.1
5	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ	1	-					1	
6	Монгол Улсын далайн захиргаа	3	6,105,377.1			2	6,105,377.1	1	
7	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	1	3,181,803.4			1	3,181,803.4		
8	Монголын төмөр зам ТӨХК	2	-					2	
9	МИАТ ТӨХК	2	-			2			
10	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХК	5	100,200.4			1	26,017.0	4	74,183.4
11	Иргэний нисэхийн үндэсний төв	34	13,134,356.3	-	-	4	697,678.7	30	12,436,677.6
12	ИНЕГ нэгтгэл	2	-					2	
13	ИНЕГ түүвэр	8	20,584,534.6			5	19,603,822.6	3	980,712.0
14	Багануур АЗЗА ТӨХК	1	49,250.0					1	49,250.0
15	Булган АЗЗА ТӨХК	1	1,000.0	1	1,000.0				
16	Дархан АЗЗА ТӨХК	1	428,038.1					1	428,038.1
17	Налайх АЗЗА ТӨХК	1	-					1	-
18	Орхон АЗЗА ТӨХК	1	-					1	-
19	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	1	800.0					1	800.0
20	Төв АЗЗА ТӨХК	1	-					1	-
21	Хөвсгөл АЗЗА ТӨХК	1	-					1	-
	НИЙТ ДҮН	84	120,083,587.3	2	3,000.0	21	68,613,433.3	61	51,467,154.0